

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАРИМ СУМЫН ТӨВИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- 1.Өмнөговь аймгийн Баяндалай, Баян-овоо, Булган, Мандал-овоо, Манлай, Ноён, Номгон, Сэврэй, Ханхонгор, Хүрмэн, Цогт-овоо сумын төвүүдийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, цэвэр, бохир усны суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн хугацааны дараа сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг дээр дурдсан сумдын Засаг дарга нар, ус хангамж хариуцсан ОНӨААТҮГ-ууд, "Гүний ус" ХХК /Ж.Энхчимэг/-д тус тус үүрэг болгосугай.
- 3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Өмнөговь аймгийн сумдыг ус хангамжийн үйлчилгээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг "Гүний ус" ХХК /Ж.Энхчимэг/-д даалгасугай.
- 4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Ж.Гэрэлчулуун/-т даалгасугай.

ДАРГАЖ.БАТСУУРЬ

ГИШҮҮНЛ.БОЛД

Ж.ДАВААЦЭРЭН
Г.ЦОГТСАЙХАН
Ч.ЭРДЭНЭЧИМЭГ